

2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт байрлах “Тоорой
шанд” нэртэй чулуун нүүрсний ордыг ил уурхайн аргаар
ашиглах төсөл

Улаанбаатар хот,
2022 он


ГАРЧИГ

Төслийн товч танилцуулга:.....	3-4
Дэлгэрэнгүй тойм.....	4-5
Төслийн гол ба болзошгүй нөлөөлийн эрчим, үргэлжлэх хугацаа.....	5-7
Уур амьсгалын байдал.....	7-8
Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө түүний биелэлт.....	8-14
Байгаль орчны менежментийн тайлангийн гол зорилго.....	14
1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	14-25
2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт.....	26-28
3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	28-29
4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	29-30
5. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	30-33
6. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	34-37
7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	37-38
8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр төлөвлөгөөний биелэлт	38-42
9. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт	43
10. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	43
11. Нэгдсэн зардал	46

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

Төслийн нэр:	“Тоорой шанд” нэртэй чулуун нүүрсний ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл :
Төсөл хэрэгжүүлэгчийн :	- “ЕАИ ” ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9011047062 - Регистрийн дугаар: 2687968 - Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл: MV-020781
Төслийн байршил:	Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг оршино: - Улаанбаатар хотоос баруун урагш 910 км, - Даланзадгад хотоос баруун тийш 340 км, - Гурвантэс сумын төвөөс зүүн урагш 65 км, - Овоотын цэргийн ангиас 38 км - Шивээ хүрэнгийн боомтоос 48 км зайд тус тус байрлана.

Төслийн талбайн байрзүйн зураг



Зураг-1 Талбайн байршилын зураг

Ашиглалтын талбайн булангийн цэг

Хүснэгт-1

Д/д	Уртлаг			Өргөрөг		
1	101	12	21.66	42	56	1.26
2	101	13	21.66	42	53	33.4
3	101	12	42.76	42	53	33.4
4	101	13	43.04	42	49	3.5
5	101	14	58.31	42	49	3.5
6	101	14	58.31	42	53	33.4
7	101	15	51.22	42	53	33.4
8	101	15	51.22	42	50	15.99
9	101	22	12.03	42	50	16
10	101	22	11.87	42	47	7.18
11	101	15	55.98	42	47	7.18
12	101	15	55.98	42	49	2.97
13	101	12	3.97	42	53	15.49
14	101	12	3.97	42	53	15.49
15	101	9	31	42	53	15.49
16	101	9	31	42	51	29.07
17	101	6	0.72	42	51	29.07
18	101	6	0.73	42	53	1.25
19	101	2	0.72	42	53	1.26
20	101	2	0.72	42	54	1.26
21	101	0	0.72	42	54	1.26
22	101	0	0.72	42	55	12.2
23	101	3	12.32	42	55	12.2
24	101	3	12.32	42	56	1.26

ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТОЙМ

Тооройн шандын ордын нүүрс нь гадаад шинж чанараараа өөр хоорондоо ялгагдахгүй гол төлөв тод хагас гялгатай, нэг төрлийн, уналын өнцөг огцом, судлын зузаан нимгэн, нүүрсний дунд шаврын үетэй нийлмэл тогтоцтой, дотоод ан цав, цавшил ихтэй, бутрамтгай шинж чанартай, гол төлөв дун маягийн хагаралтай байна. Нүүрсэнд хоёрдогч эрдсийн мөхлөгүүд ховор, зөвхөн пиритийн жижиг мөхлөгийн өнгөр байдалтай хуримтлал бага гүнийн нүүрсэнд хааяа ажиглагдаж байна.

MV-020781 тоот тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд 2007-2010 онуудад “Саусгоби Сэндс” ХХК-ийн геологчид тодорхой хэмжээний эрэл хайгуулын ажлыг гүйцэтгэж, талбайн баруун хэсэгт байрлах Тооройн шандын нүүрсний илрэлийн хэтийн төлөвт үнэлгээ өгөх зорилгоор суваг малталт, кернтэй болон хийн үлээлгэлтэт технологээр өрөмдлөгийн ажил гүйцэтгэж, нүүрсний 3 давхаргыг илрүүлсэн байна. Нүүрсний давхаргын харагдах зузаан нь 3.0-20.0 м, уналын өгцөг 60⁰-80⁰ хэм байна. 2008 онд Тооройн шандын хэсэгт 1983.56 м³ буюу 10 суваг малталт, 2493 тууш метр 10 цооногийг өрөмдсөн. 2009 онд 2116.1м³ 10 суваг малталтын ажил, 700 тууш метр өрөмдлөгийн ажлыг тус тус гүйцэтгэсэн. 2010 онд 2757.44м³ суваг малталт 6325

тууш метр 26 цооног өрөмдөж нүүрсний хэтийн төлөв өндөртэй, нөөц өсөх магадлалтай гэж тооцоолсон.

2010 онд өрөмдсөн NSSW10-10R дугаартай кернгүй цооног нүүрсний давхаргадсын харагдах зузаан 20 м орчим байгаа нь уг нүүрстэй хэсэгт нүүрсний давхарга ордын хэмжээнд хүрч зузаарах боломжтойг харуулсан байна. Ашигт малтмалын газрын Кадастрын албаны даргын 2015 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 31 тоот шийдвэрээр ХҮ-017706 тоот тусгай зөвшөөрлийг Тооройн шандын нүүрсний ордын 9449Х талбайгаас “ЕАИ” ХХК-нд хэсэгчлэн олгосон.

ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛИЙН ЭРЧИМ, ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА :

Ашигт малтмал олборлох, уул уурхайн үйлдвэрлэл явуулах үед байгаль орчны төлөв байдал, орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллүүдийн хэлбэр, тэр нь эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх эсэхийг болон нөлөөллийн үргэлжлэх хугацаа, түүний эрчимшил зэргийг тодруулахын тулд магадлан жагсаах аргыг хэрэглэдэг билээ.

Энэ арга нь ашигт малтмал олборлох уурхайн ашиглалтын үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг бөгөөд хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"- ээр тэмдэглэдэг.

"ЕАИ" ХХК-ий ил аргаар нүүрс олборлох Галын овоо-1 ил уурхайн төсөл хэрэгжсэнээр байгаль орчны төлөв байдал, экологи, орон нутгийн нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн үнэлгээг магадлан жагсаах аргаар гүйцэтгэж хүснэгт №-1-д үзүүлэв.

“ЕАИ” ХХК-ний Нүүрсний орд ашиглах төслөөс орчны төлөв байдал, бүс нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллүүдийн хэлбэр, түүний эрчимшил зэргийг магадлан жагсааж, болзошгүй нөлөөллийг тодрууллаа.

Төсөл хэрэгжих үеийн байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Хүснэгт-2

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицоллох	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1.Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт	х				х		х		х	
Газрын доорх усны чанарын өөрчлөлт	х				х		х		х	
Гадаргын усны урсацын өөрчлөлт										
Ургамлын бүтцийн өөрчлөлт	х		х				х	х		
Хөрсний элэгдэл, эвдрэл	х				х		х	х		
Геологийн тогтоцын өөрчлөлт	х				х		х	х		
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт		х		х			х		х	
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт	х			х			х		х	
2.Байгалийн нөөц, ашиглалт										

Газрын гадаргын нөөц баялаг	x				x		x		x	
Бэлчээрийн байдал	x			x			x		x	
Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x		x	
Эрчим хүчний нөөц	Нөлөөлөл байхгүй									
3.Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ	x				x		x	x		
Агаарын бохирдол	x		x			x		x		
Хөрсний эвдрэл, бохирдол	x				x		x	x		
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх		x			x	x				x
Дуу чимээ, шуугианы нөлөө	x			x			x		x	
4.Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	x				x		x	x		
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x	x		
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй									
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй									
Археологи, палентологийн олдворт нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй									
5.Нийгэмд үзүүлэх нөлөө										
Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх	x			x			x			x
Хүн амын орлого өөрчлөгдөж нэмэгдэх	x			x			x		x	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x		x		x				x
6.Эдийн засаг, байгаль орчин										
Татварын орлого өөрчлөгдөх	x			x			x		x	
Бүс нутгийн орлого нэмэгдэх	x			x			x		x	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x			x			x		x	
Ажлын байр нэмэгдэх	x			x			x		x	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x			x			x		x	
7.Бусад нөлөөлөл										
Уурхайн болон ахуйн бохир уснаас хөрс, ус бохирдох	Зөөврийн бохирын системд холбогдоно									
Шороон зам харилцаа, уурхайн машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	x				x		x	x		
Дүн	24	3	2	13	12	3	24	9	15	3

Эдгээр болзошгүй нөлөөллүүдийг хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмээр нь тодруулбал:

Шууд нөлөөлөл: Болзошгүй нөлөөллийн 24 (81,5%) нь шууд нөлөөлөлд хамрагдаж байна. Нүүрсний орд ашиглах төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгийн өөрчлөлт, хөрсний элэгдэл эвдрэл, бэлчээрийн нөөц багасах, газрын доорх усны чанарт, геологийн тогтоц, ландшафтын хэлбэр, хүрээлэн буй орчин, тусгай хамгаалалттай газар нутаг зэрэгт сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Шууд бус нөлөөлөл: Уг төслөөс нийт болзошгүй нөлөөллийн 3 (18,5%) нь шууд бус нөлөөлөлд хамрагдаж байна. Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт, Уур амьсгалын (бичил) өөрчлөлт, Хорт

бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх, Үйлчилгээний салбар зэрэгт шууд бусаар нөлөөлөхөөр байна.

Өөрөө зохицуулагдах нөлөөлөл: Нүүрсний орд ашиглах төслөөс нийт болзошгүй нөлөөллийн 2 (7,4%) нь өөрөө зохицуулагдах нөлөөлөлд хамрагдаж байна.

Богино хугацааны нөлөөлөл: Уг төслөөс нийт болзошгүй нөлөөллийн 13 (44,4 %) нь богино хугацааны нөлөөлөлд орж байна. Богино хугацааны нөлөөлөлд зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт, уур амьсгалын (бичил) өөрчлөлт, бэлчээрийн байдал зэрэг богино хугацаанд өөрөө зохицуулагдах нөлөөлөл гэж авч үзлээ.

Урт хугацааны нөлөөлөл: Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн 12 (48,1%) нь урт хугацааны нөлөөлөл бөгөөд төслийн байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийн ихэнхи нь урт хугацааны нөлөөлөлд хамрагдаж байна.

Нөлөөллийн эрчим: Төсөл хэрэгжих орчны байгаль орчинд тухайн төслөөс гарах хүчтэй нөлөөлөл их бөгөөд талбайн болон түүний орчны хөрс, ургамлын элэгдэл, байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх, агаар, хөрс, усны бохирдол, ландшафтын хэлбэр өнгө өөрчлөгдөх зэрэг нөлөөллүүд байна. Дунд зэргийн эрчимтэй нөлөөлөлд газрын гадаргын нөөц баялаг, зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт, татварын орлого, бүс нутгийн орлого нэмэгдэх зэрэг нөлөөллүүд багтана.

Бага зэргийн эрчимтэй: нөлөөлөлд хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх, үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх, хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх зэрэг нөлөөллүүд багтаж байна. Нийт 27 нөлөөллөөс 10 хүчтэй, 14 дунд зэргийн, 3 бага зэргийн нөлөөлөл байна.

ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН УУР АМЬСГАЛЫН НӨХЦӨЛ

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт өвс ургамалтай, ургамалгүй гадарга, баян бүрд, булаг шанд, уул нуруу, хотгор, хөндий, тэгш тал, говь цөл хослон оршдог нь уур амьсгалын өвөрмөц нөхцөлийг бүрдүүлнэ.

Тооройн шандын нүүрсний орд орчмын нутаг дэвсгэр нь цаг уурын хувьд эрс тэс уур амьсгалтай, өвөлдөө цас багатай, хүйтний эрч бага, хавар хүйтэвтэр, шороон шуурга элбэгтэй, салхины чиглэл тогтворгүй, зундаа хуурай халуун уур амьсгалтай. Эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвөл -15°C-аас -20°C хүйтэрч, зун +30°C -аас +35°C заримдаа +40°C-аас давж хална. 1 сард агаарын дундаж температур -15°C -аас -18°C, 7-р сард агаарын дундаж температур +20°C-аас +25°C. Жилийн агаарын дундаж температур +2°C-аас +5°C байна. Жилийн дунджаар авч үзвэл салхигүй өдрийн тоо 10-15 хоног. Хамгийн их салхи хавар тохиолдох бөгөөд дунджаар 5.9 м/сек, хамгийн бага салхитай улирал нь өвөл бөгөөд салхины хурд дунджаар 4.2-4.3 м/сек ба жилийн 30-35 хоног 15 м/сек хүртэл хүчтэй цасан болон шороон шуургатай байдаг.

Агаарын температур

Гурвантэс сумын нутагт жилийн агаарын дундаж температур 5.6°C байдаг. Энэ район нь говь цөлийн ширүүн уур амьсгалтай. Өвөл нь 15-20°C хүйтэн, зун, намрын саруудад маш халуун болж агаарын температур (+3°C-35°C), зарим үед +40°C хүрдэг. Жилийн хамгийн хүйтэн 1 дүгээр сард агаарын дундаж температур -23°C, хамгийн их халуун 8 дугаар сард агаарын дундаж температур +30°C орчим, агаарын үнэмлэхүй хамгийн их температур +39.8°C, үнэмлэхүй бага

температур -40°C байдаг. Гурвантэс сумын цаг уурын станцын мэдээгээр $+30^{\circ}\text{C}$ -аас халуун өдрийн тоо жилд дунджаар 31 байна.

Хур тунадас

Тус бүс нутагт хур тунадасны уналт их биш, жилийн дундаж хур тунадас 82.4 мм, үүний 60 хувь нь зуны улиралд ордог байна. Гурвантэс сум нь уур амьсгалын нэн хуурай дулаан говь, цөлийн бүсэд багтана. Нэн хуурай дулаан говь, цөлийн бүсийн уур амьсгалын ерөнхий онцлог нь агаар, хөрсний чийгээр дутмаг байдаг. Хур тунадас маш бага унадаг, ялангуяа 1970-аад оноос хойш тунадасны хэмжээ улам багасаж зун, намрын саруудад гандуу байдаг болсон. Өвөл цасны бүрхүүлийн зузаан 0-3 мм, зун нь хур тунадасны хэмжээ 30-60 мм, жилд дунджаар 51 мм орчим тунадас унадаг болсон байна.

Агаарын даралт

7 дугаар сарын агаарын хоногийн дундаж даралт 849.2-862 мм м.у.б., 3 дугаар сард 857.5-875.6 мм м.у.б -д хүрч харьцангуй чийгшлийн дундаж 40–49 % болдог байна.

Нарны гэрэл

Нарны гийгүүллийн үргэлжлэх хугацаа жилд 2900 орчим цаг, үүнээс дулааны улиралд 1960 цаг байна. Энд үүл, хур тунадас багатай, нарны гэрлийн эрчим хүч ихтэй юм.

Салхины горим

Тооройн шанд нүүрсний орд орчмын салхины горим өвөрмөц орон нутгийн шинжтэй салхины жилийн дундаж хурд 2.0-2.7 м/сек; хамгийн их хурд 14 - 30 м/сек -д хүрдэг. Өвөлдөө баруун, өмнөд зүгийн салхи зундаа баруун, баруун хойд зүгийн салхи зонхилдог нь тус газар нутгийн геологийн тогтоцтой холбоотой. Харин 4 дүгээр сарын салхины дундаж хурд 4.0 м/с хүрдэг байна. Салхигүй үеийн давтагдал өвөл 12-1 сард 52.5-62.6% байдаг бол 4 дүгээр сард энэ нь 31.3% хүртэл буурдаг. Энэ сард өдрийн 13 цагийн салхигүй үеийн давтагдал дөнгөж 9.6% байна. Иймд хаврын улиралд өдрийн цагт их төлөв салхитай байдаг бөгөөд 13 цагийн салхины дундаж хурд 4 дүгээр сард 4 м/сек орчим байна. 4, 5 дугаар саруудад хүчтэй салхи 10-15 удаа тохиолдоно. Жилд дунджаар 25 өдөр шороон шуургатай байдаг. 4, 5 дугаар саруудад 3-4 удаа шороон шуурга болдог.

Хөрсний гадаргын температур

Энэ нутагт хөрсний гадаргын жилийн дундаж температур 9.2°C , дулааны улиралд хөрсний гадаргын температур дунджаар $+25^{\circ}\text{C}$ байдаг бөгөөд 7 дугаар сард $+34^{\circ}\text{C}$ байна. Гэхдээ зуны халуун өдөр хөрсний гадарга маш их халах тохиолдол байдаг. Хөрсний гадаргын жилийн үнэмлэхүй их температур 62°C . Хөрсний хөлдөлтийн хэм 0.8-1.8 м байдаг.

Цасан бүрхүүл, цастай өдрийн тоо

Цасан бүрхүүлийн зузаан дунджаар 2-3 см-ээс хэтэрдэггүй, цасан бүрхүүлийн үнэмлэхүй зузаан нь 16 см байдаг. Жилд цасан бүрхүүлтэй өдрийн тоо 33 байдаг бөгөөд хүйтний улиралд сард 1-3 удаа цас ордог байна. Цас орой унаж (12-р сарын сүүлч, 1-р сарын эхээр) хавар эрт (2-р сарын сүүлчээр) хайлна. Бороотой өдрийн тоо жилд дунджаар 22 байдаг.

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Төслийн агаарт нөлөөлөх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ:

- Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдэд Монгол Улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд болон олон улсын холбогдох стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж түүнд нийцүүлнэ.
- Усны машин ашиглан тоосжилт үүсэх замуудыг услах, чийглэх, замыг дагтаршуулах.
- Хучилтгүй зам дээр тээвэр хийх машины хурдыг хязгаарлаж, хурдны хязгаарлалтыг анхааруулсан замын тэмдэг, тэмдэглэгээ байршуулах.

Төслийн гадаргын болон газрын доорхи усанд нөлөөлөх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ.

- Нүүрсний ордыг ашиглах үйл ажиллагааны үед газрын доорхи усны шинж, химийн найрлагын өөрчлөлтийг судлахын тулд дээж авч судалгааг хийх.
- Усны хэрэглээнд хяналт тавьж, хэрэглэсэн усны балансыг гаргаж байх.
- Үйл ажиллагаа явуулах үед машин техник, тоног төхөөрөмжийн элэгдсэн эд анги, хөдөлгүүрийн шингэн, шатахуун, тос маслын хаягдал ба тээвэрлэлтээс үүсэх хорт бодис, шороо тоосны ялгаралт нь усыг бохирдуулахаас сэргийлэх.
- Ахуйн бохир усаар газрын доорх ус бохирдохоос сэргийлэх.
- Унд ахуйн усны эх үүсвэрийн ариун цэврийн хамгаалалтын бүсэд мөрдөх журам гарган мөрдөж ажиллах.
- Тосгон ба ордыг хаврын шар усны болон хур борооны үерээс хамгаалах арга хэмжээ авах, сайжруулах (суваг, хамгаалалтын далан гэх мэт).
- Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор орчны хяналт шинжилгээ хийлгэх арга хэмжээ авч усны чанар, нөөцөд хяналт тавьж ажиллах.
- Өмнөх байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд дурдагдсан усны нөөц чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах зөвлөмжийг сайтар биелүүлж ажиллах.
- Хэрэв бохир ус зөөвөрлөж хаях бол гадаргын урсацаас ангид газарт сумын мэргэжлийн байгууллагын зөвшөөрлөөр зориулалтын машинаар гүйцэтгэх.
- Орчны хяналт шинжилгээний хүрээнд тухайн байгууллага нь санал нэгтэй хүлээн зөвшөөрөхүйц үр дүнд хүрэх зорилгоор олон нийтийн төлөөлөл, байгаль орчны байцаагчийн оролцоотой усны хяналт шинжилгээ хийх (Уснаас дээж авах зэрэгт).
- Усны дээж авахдаа MNS ISO 5667-1-2002, MNS ISO 5667-3-1999, MNS ISO 5667-4-2001, MNS ISO 5667-10-2001 стандартын арга аргачлалын дагуу авч гүйцэтгэх.

Төслийн хөрсөн бүрхэвчид нөлөөлөх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

- Хөрсний мониторингийн цэгүүдэд тогтмол хугацаанд хэмжилт хийж байх.

Бууруулах арга хэмжээ

- Хуурай халуун улиралд том машин механизмийн замын усалгааны хугацааг ойртуулах, машин механизмын хурдны хязгаарыг багасгах.
- Ямар ч газар шорооны үйл ажиллагаа эхлэхээс өмнө эвдэгдэх, хөндөгдөх хөрсийг өндөрлөг, налуу хажуу хэсэгт өнгөн хэсгийн давхаргийг тусад авч хадгалах, биологийн нөхөн сэргээлтэндээ ашиглах.
- Хөрс бохирдуулж болзошгүй хог хаягдлыг ангилж ялгах, хөрсөнд алдагдахааргүй хадгалах. Хөрс бохирдуулахааргүй хадгалах газраа тохижуулах орчиндоо тараахгүй байх талаар арга хэмжээ авах (хашаа хаалт барих) гэх мэт арга хэмжээ авч хэрэгжүүлэх. Хог хаягдлыг ангилал, шинж чанараас нь хамааран (Шингэн хог хаягдлыг тухай бүрд нь цэвэрлэж зөвшөөрөгдсөн газарт зөөвөрлөх, ариутгах ажлыг хийж байх, гадны нөлөөлөлөөс тусад нь байлгах, амьтан, ургамал нөлөөлөхөөргүй нөхцөлд байршуулах), хог хаягдлын цэгтэй нь байх, салхи шуургатай үед хог хаягдал хийсч орчноо бохирдуулахгүй байх ёстой) түүнд таарсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- Уурхай орчим, доторх зам талбайг тодорхой зам-нэгдсэн нэг зам ашиглах талд дээр анхаарах. Тухайлбал: Замын тэмдэг тэмдэглэгээг сайтар байршуулах, зам ашиглах тал дээр уурхайн зүгээс хатуу бодлогыг баримтлах нь хөрсөн бүрхэвч эвдрэх эрсдэлээс сэргийлж чадна.
- Уурхай орчмын зогсоол, замд машин техникийн шатах тослох материал асгарвал тухай бүрд нь саармагжуулах, бүртгэлжүүлэх
- Халуун хуурай улиралд уурхайн үйл ажиллагааны явцад хөрсний гадаргаас авто машин, техникийн хөдөлгөөнөөс үүдэлтэй, мөн уурхайн карьерын эвдэгдсэн гадаргуугаас тоосжилт бий болох нь даамжиггүй бөгөөд тоосжилтыг багасгахын тулд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлбэл зохилтой:
- Машин техникийн хөдөлгөөний хурдыг хөрсний гадаргын шинж чанараас хамааруулан тогтоох. Тухайлбал тоосжилт их гарч буй гадаргад хурдны хэмжээг багасгах.
- Тоосжилт их үүсэж буй гадаргууд тодорхой хугацаанд услагаа хийх, Их салхи шуургатай тохиолдолд машин техникийн хөдөлгөөнийг хязгаарлах.

Төслийн ургамлан нөмрөг, амьтны аймагт нөлөөлөх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ.

Урьдчилан сэргийлэх чиглэлээр:

- Олборлолтын ажлын явцад техникийн ба биологийн нөхөн сэргээлтийн ажлыг холбогдох стандарт горимын дагуу төлөвлөж явуулах ёстой.
- Ургамлан нөмрөг, зонхилгч төрөл зүйлүүдийн мониторингийг жил тутамд хийж ургамалжилтын хэв шинжийн өөрчлөлтийг ажиглах.
- Амьтны аймгийн мониторингийг жил тутамд хийж байх *Бууруулах чиглэлээр:*

Уурхайн үйл ажиллагаанаас хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөлөл.

Тоосжилт.

Нүүрсийг ил аргаар олборлоход их хэмжээний тоос гарах нөхцөлийг бүрдүүлдэг. Уурхай хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажилд өрөмдлөг тэсэлгээний арга хэрэглэх, экскаватор автосамосвалын хослолоор хөрс, нүүрс ачиж, тээвэрлэх, хөрсний овоолго байгуулах зэрэг технологийн үйл явцад мөн салхи ихтэй нөхцөлд тоос ихээр гарч агаар орчныг бохирдуулдаг байна.

Тоосны бохирдолтын нэг удаагийн хамгийн их агууламж нь 0.5г/м^3 -ээс их бол хүмүүсийн эрүүл мэндэд нөлөөлж эхэлдэг байна. Иймээс энэ хязгаарын утгыг зөвшөөрөгдөх дээд хэмжээ гэж эрх бүхий байгууллагаас стандарчилан тогтоож өгсөн.

Хэрэв тоосжилтын нэг удаагийн хэмжилтээр агууламж нь 0.25г/м^3 -ээс их бол бохирдолтой гэж үзэж болно.

Тооройн шандын нүүрсний ордыг ил аргаар ашиглах үед нүүрс олборлолт, хөрс хуулалтын ажил хийх, тэсэлгээ явуулах, хөрс нүүрс ачих, тээвэрлэх, овоолго байгуулах зэрэг үйл ажиллагааны явцад их хэмжээний тоос тухай бүр салхины хурдаас хамааран үүсэж агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болох магадлалтай байна.

Төсөл хэрэгжүүлэх үед гарч болзошгүй байгалийн гамшгийн нөлөөлөл

Гал түймэр: Төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэр нь гал түймрийн аюул, осол багатай бүс нутаг дэвсгэр нь гал түймрийн аюул, осол багатай бүс нутагт хамрагдах боловч хавар, хамрын улиралд салхи ихтэй байдаг учир ил задгай газарт гал гаргахаас болгоомжлох нь чухал.

Нүүрсний өөрөө шаталтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй тохиолдолд уурхайн нүүрсний мөргөцөгт өөрөө шаталт гарах магадлалтай.

Нүүрсний уурхай нь жил бүрийн уулын ажлын төлөвлөгөөндөө галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусган хэрэгжүүлэх шаардлагатай.

Гал түймрээс урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг байнга авах, гал түймрийг утраах багаж хэрэгслээр хангасан байх шаардлагатай.

Нүүрсний өөрөө шаталт гарсан тохиолдолд түүний тархалтыг зогсоох арга хэмжээг нэн даруй авч, шаталт үүссэн хэсгийг тусгаарлах шаардлагатай.

Аянга, цахилгаан: Өмнөговь аймгийн цаг уурын албаны мэдээллээр уурхай байгаа газарт болон түүний орчимд урьд өмнө нь аянга бууж байсан тухай тэмдэглэгдсэн зүйл үгүй байна. Орчны нөхцөл байдлыг дүгнэн үзэхэд аяндын нөлөөлөлд өртөх магадлал бага гэж үзэж болно. Гэвч аюулгүй ажиллагааны үүднээс суурин тоног төхөөрөмжүүдийг байнгын аянга зайлуулагчтай байлгах шаардлагатай.

Үер: Зун намрын улиралд зарим нэг тохиолдолд их устай аадар бороо орсноос шалтгаалан уурхайн ашиглалт явуулж буй талбайд ихээхэн хэмжээний үерийн ус цутган орсноос ослын байдал гарч болно.

Уурхайн ухаш усаар дүүрснээр технологийн тоног төхөөрөмж тухайлбал экскаватор, бульдозер, автосамосалуудын ажил зогсож сул зогсолтын алдагдал гарахаас гадна уг усыг зайлуулж шавхахтай уялдсан нэмэлт зардал нь уурхайд эдийн засгийн хохирол учруулна.

Газар хөдлөлт: Тооройн шандын нүүрсний орд орчмын газар нутаг нь газар хөдлөлтийн 6-7 баллын бүсэд хамаарна.

Орон сууцны болон үйлдвэрлэлийн барилга байгууламжууд нь газар хөдлөлтийн нөхцөлд нурах онц аюултайгаас гадна уурхайн байгууламжууд нь газар хөдлөлтийн нөхцөлд

нурах онц аюултайгаас гадна уурхайн болон овоолгын догол мөргөцгүүд ан цав үүсэж хагарч нурах, гулсалт гарах аюултай. Иймд технологийн шаардлагыг хангасан барилга байгууламж барих хэрэгтэй.

2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАНГИЙН ЗОРИЛГО

Тайлангийн зорилго нь байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, аливаа бохирдлын түвшинг хянаж арилгах, ногоон байгууламж нөхөн сэргээлт хийх зэрэг ажлын хэрэгжилт, хугацаа, шаардагдсан төсөв үр дүн зэргийг нэгтгэж гаргах юм.

Үүнд:

- ✓ Байгаль орчны бүх хууль, тогтоомжуудыг даган мөрдөх;
- ✓ Байгаль орчныг хамгаалах шилдэг аргуудыг үйл ажиллагаандаа бий болгох удирдлагын системийг хэрэгжүүлэх;
- ✓ Бүхий л үйл ажиллагаандаа "багасгах, дахин ашиглах, дахин боловсруулах" зарчмыг хэрэгжүүлэх;
- ✓ Ажилчиддаа байгаль орчноо хамгаалах хариуцлагыг нь ухамсарлуулан ойлгуулах, энэ тухай явуулах сургалтанд хамруулах;
- ✓ Байгаль орчныг хамгаалах үүргээ цаашид улам идэвхжүүлэх;
- ✓ Байгаль орчныг хамгаалах нь бидний үйл ажиллагааны чухал нэгэн хэсэг юм;
- ✓ Ашигт малтмал олборлогч аж ахуйн нэгжийн мөрдөх хууль, стандартыг хангуулах;
- ✓ Компанийн дотоод дүрэм, журам, горимд байгаль орчныг хамгаалах зорилгыг хэрэгжүүлэх заалтуудыг багтаах;
- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний заалтуудыг шат дараатай хэрэгжүүлэх.

1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

1.1. Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ

- Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн гарах сөрөг нөлөөллийг бууруулах болон арилгах арга хэмжээ, шаардагдах зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд жил бүр тусган хэрэгжүүлж, байгаль орчныг хамгаалах талаар хийсэн ажлын биелэлтийг холбогдох газруудад тайлагнаж байх;
- Орон нутгийн засаг захиргаа болон байгаль орчны байцаагчидтай байнгын харилцаа холбоотой ажиллах;
- Ажиллагсдад байгаль орчныг хамгаалах асуудлаар сургалт, семинар хийх, заавар зөвлөгөө өгөх ажлыг тогтмол зохион байгуулах;
- Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, байгаль орчныг доройтуулахаас сэргийлэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгаа хийх, анхааруулга, санамжийн хуудас бэлтгэж зохих газруудад байрлуулах;
- Машин техникийн засвар хийх, шатах тослох материал хадгалах, машин техникийг цэнэглэх ажлыг зориулалтын тусгай талбайд явуулж байх;

- Шатах тослох материалыг зориулалтын тусгай агуулахад зохих шаардлагын дагуу хадгалах;
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авах арга хэмжээний зөвлөмжид тусгасан арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх асуудлыг байгаль орчны асуудал хариуцсан ажилтанд хариуцуулж, биелэлтийг холбогдох газруудад тогтоосон хугацаанд тайлагнаж байх;
- Улс, орон нутгийн төсөвт оруулах ёстой татвар, төлбөр, хураамжийг тогтоосон хугацаанд барагдуулж байх;
- Өөрийн үйл ажиллагааны талаар тухайн орчинд оршин суугаа иргэдэд тогтмол танилцуулах, үнэн зөв мэдээлэл өгч байх.

1.2 Агаарын бохирдлыг бууруулах, арилгах

- Орчны болон ажлын бүсийн агаар дахь тоосны хэмжээг нэмэгдүүлэхгүй байх нөхцөлийг хангах, хяналт-шинжилгээг тогтмол хийлгэж байх;
- Уурхайн олборлолтын үйл ажиллагаа харьцангуй хуурай орчинд явагдах тул ердийн замаар автомашин болон хүнд механизм явах үед агаарт дэгдэх тоос шороог багасгах арга хэмжээ авах, хөрсийг тогтмол усалж чийглэж байх;
- Шатах, тослох материалаар машин техникийг цэнэглэх үед нефтийн бүтээгдэхүүний ууршилт үүсэж, агаар бохирдуулахаас сэргийлэх;
- Нүүрс олборлох, хөрс ачилт, нүүрсийг ачих, тээвэрлэхэд тоос шороо үүсэх, агаар бохирдуулахаас сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;
- Уурхайн хүнд механизм, машин техник ажиллах үеэр дотоод шаталтат хөдөлгүүрийн шатахууны дутуу шаталтаас төрөл бүрийн хорт хий ялгарч агаар бохирдуулахаас сэргийлэх;
- Түлшний шаталтаас хорт хий үүсэхээс сэргийлж машин техникийг тогтмол үзлэг, оношилгоонд оруулах, машин техникийн янданд шүүлтүүр тавих, утааны хэмжилт хийж байнгын хяналт тавьж ажиллах;
- Ахуйн бохир усыг ил задгай хаях, бохир усны цооногийн усыг тогтоосон хугацаанд зайлуулахгүй халиулах зэргээс орчин тойрны агаарт ууршилт үүсэх нөхцөлтэй тул ахуйн бохир усны цооногийг зохих шаардлагын дагуу доторлож ашиглах, бохир усыг тогтмол хугацаанд зөөвөрлөж, мэргэжлийн байгууллагаас тогтоосон цэгт зайлуулж байх;
- Хог хаягдал, хоол хүнсний үлдэгдлийг ил задгай хаях болон тогтоосон хугацаанд зайлуулаагүйгээс ялзарч муудах, агаарт эвгүй үнэр гаргаж орчны агаарыг бохирдуулах зэргээс халдварт өвчин тархаж болзошгүйг анхаарч, хог хаягдлыг зориулалтын тусгай цэгт, тагтай саванд хадгалж, төвлөрсөн цэгт тогтмол хугацаанд зөөвөрлөн зайлуулж байх.

1.3 Усны нөөцийг бохирдол, хомсдолоос сэргийлэх

- Усны чанарын шинжилгээг тогтмол хийлгэж байх;
- Ажиллагсдын тосгоны цэвэр ус хангамжийн асуудлыг зохистой шийдвэрлэх, унд-ахуйн хэрэгцээнд ашиглах усанд химийн болон эрүүл ахуйн шинжилгээг тогтмол хийлгэж, дүгнэлт гаргуулж байх.

1.4 Хөрс болон ургамлан нөмрөгийг хамгаалах

- Автомашины зогсоолын талбайг тэгшлэн шатах, тослох материал хөрсөнд нэвчихээс сэргийлж цардаж өнгөлөх, тэмдэгжүүлэх;
- Олон салаа зам гаргахгүй байх, уурхай руу очих, буцах замын маршрутыг тодорхой тогтоож, тэмдэгжүүлэх, уурхайн орчны замд дэвсэлт хийх, шороон зам, хаягдлын овоолгоос тоосжилт үүсгэхгүй байх зорилгоор чийгшүүлэлт хийж байх;
- Нүүрсний уурхайн орчмын нутаг дэвсгэрийн ургамлын төрөл зүйл, тархалт, өсөлт хөгжилтөд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх;
- Ажиллагсдын тосгон байгуулахад өртөж эвдэрсэн газрыг засаж тэгшлэх, ургамалжуулах, мод суулгац тарих
- Засвар үйлчилгээний талбайд хучилт хийх

1.5 Хог хаягдлыг бууруулах талаар авах арга хэмжээ

- Бохир усны цооног, бие засах газар, түүний орчны хөрсийг эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагын зөвлөмжийн дагуу тогтмол ариутган халдваргүйжүүлж байх;
- Хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, эргүүлж ашиглах боломжтой хэсгийг холбогдох газруудад нийлүүлэх, боломжгүйг нь хог хаягдлын нэгдсэн цэгт тогтоосон хугацаанд зайлуулж, орчны хөрс, ус бохирдохоос сэргийлэх арга хэмжээг тогтмол авч байх;
- Тогтоосон цэгээс бусад газар хог хаягдал хаяхыг хориглох.

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ТҮҮНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт-3

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөлийг арилгах, бууруулах арга хэмжээ	Төсөв /төг /	Аргачлал стандарт	Төлөвлөгөөний биелэлт
Агаар орчин үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах					
1.1	Уурхайн орчимд болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах, дагтаршуулах	Усны машин түрээслэн тоосжилт үүсэх зам, талбайнуудыг услах, замыг засч дагтаршуулах арга хэмжээ авсанаар тоосжилтыг багасгана.	56'632'674	Агаарын тухай хууль, 9, 11, 23-р зүйл MNS 4585:2007	Уурхай нь 2022 оны 09 сарын 6-ний өдрөөс үндсэн траншей нээж технологийн замуудыг тавьж эхэлсэн. Уурхайн технологийн замуудад тохирох материалыг мөргөцгөөс авч хучилт хийж бульдозер болон грейдерээр хусч тэгшлэн дагтаршуулсан. Ажлын талбайг өглөө, өдөр, орой буюу 3 удаагийн давтамжтай “Монголын Алт” (МАК) ХХК-ийн ил уурхайн шүүрлийн усны зумфээс 9 сарын 5-аас 10 сарын 25 хүртэл мөн өөрийн уурхай дотор байгуулсан зумфээс тус тус усны насосоор соруулж усалгааг 2 цагт 1 удаа хийж тоосжилтыг дарж байгаа ба талбайн орчимд маш бага тоосжилт үүсэж байна.
1.2	Уурхайн орчимд болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах, дагтаршуулах	Жилд 2 удаа орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу орчин дахь тоосны хэмжээг тодорхойлж байх	400'000	Гадаад орчны агаарын түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж болон зөвшөөрөгдөх түвшин стандарт MNS5916:2008	Уурхайн эхлэхийн өмнө газрын төлөв байдлын хянан баталгаа “Геобатаник” ХХК – аар хийлгэж холбогдох төрийн байгууллагаар баталгаажуулсан. Тус БОНБНУ-ний тайланд орчний хяналт шинжилгээний ажлыг тусгасан. Олборлолт эхэлсний дараа орчний хяналт шинжилгээний хүрээнд Өмнөговь аймгийн ЦУОГ-тай гэрээ хийж Засвар үйлчилгээний төвийн орчимд 1 цэг, уурхай орчимд 1 цэг, Хотхоны орчимд 1, гаалийн хяналтын талбай орчимд 1, овоолго 1, шимт хөрс 1 цэг нийт 6ш дээж авч шинжилгээ хийлгэсэн.
2. Гадаргын ба гадаргын доорхи усны нөөц					

2.1	Ашиглаж буй усны чанар муудах хүрэлцээ бага байх	Ус ашиглах дүгнэлтийг жил бүрийн эхэнд гаргуулах	Уурхайн үйл ажиллагаагаар	Усны тухай хууль , Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль Усан орчны чанарын үзүүлэлт MNS 4586:1998	Ус ашиглуулах дүгнэлтийг 2022 оны 06 р сарын 02-ны өдөр Өмнөговь аймгийн усны сав газраар гаргуулж ус ашиглах гэрээг “АЛТАЙН ӨВӨР ГОВИЙН САВ” газартай 2022 оны 06 дугаар сарын 24 ны өдөр 22/06 дугаартай гэрээ байгуулсан
2.2		Ус ашигласны төлбөрийг цаг тухайд тогтмол хугацаанд төлөх	645’000	Усны тухай хууль,Ус бохирдуулсны төлөрийн тухай хууль	Усны төлбөрийг 2022 оны 06-р сарын 03-ны өдөр ус ашиглах гэрээний дагуу 645,000 төгрөг төрийн сангийн тусгай дансанд байршуулсан
2.3		Унд ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийх		Усан орчны чанарын үзүүлэлт MNS 4586:1998	Өмнөговь аймгийн усны газар нян, бактер, усны хатуулгийн шинжилгээ хийлгэсэн.
3. Хөрсөн бүрхэвч					
3.1	Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс овоолго ,уурхайн тосгон, бусад байгууламжийн доор дарагдаж элэгдэл, эвдрэлд өртөнө.	Овоолго болон бусад байгууламжуудыг байгуулахын өмнө өнгөн хөрсийг хуулан авах.	Дотоод үйл ажиллагаагаар	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай Монгол улсын хууль MNS 5914:2008	Уурхайн ашиглалт явуулах хүрээн дэх, Хөрсний овоолго үүсгэх талбай дахь, засвар үйлчилгээний төв байгуулах талбай дахь, Хотхон байгуулах, шимт хөрсний овоолго үүсгэх, гаалийн хяналтын талбай дахь, технологийн замуудын шимт хөрсийг 20-30см-ийн зузаантай хусаж, бөөгнүүлэн ачилт, тээвэрлэлт хийж шимт хөрсний овоолгод байршуулсан.
3.2		Хуулж авсан өнгөн хөрсийг тусгайлан овоолго байгуулан хадгалах	Дотоод үйл ажиллагаагаар	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 591652008	Шимт хөрсийг хуулж авч тусгайлан бэлдсэн талбайд стандартын дагуу овоолго үүсгэн дагтаршуулж хадгалж байна.
3.3	Уурхайн замын ачааллаас хөрс элэгдэж, эвдрэлд орох	Хүнд машин механизм явах замыг засаж сайжруулан, байгалийн хөрс бүхий замаар тээвэрлэлт аль болох бага хийх	Дотоод үйл ажиллагаагаар	Газар шорооны ажлын үед шимт,хөрс хуулалт хадгалалт	Уурхайн технологийн замуудын шимт хөрсийг хуулж дунджаар 30см-ийн хучилт хийж хөрсөн бүрхэвчийг гэмтээхгүй арга хэмжээг авсан

	Засварын талбайд машин механизмын хөдөлгөөнөөр хөрс эвдэгдэх	Хайрган хучилт дэвсэх	Дотоод үйл ажиллагаагаар	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай Монгол улсын хууль MNS 5914:2008	Засвар үйлчилгээний төвийн талбайн хөрсийг эвдрэх, гэмтэх, бохирдохоос хамгаалах зорилгоор 26.5га талбайд дунджаар 2м-ийн зузаантай хайргаар хучилт хийж дэвссэн
4. Газрын хэвлийн					
4.1	Нүүрс олборлосноор газрын хэвлийд хоосон орон зай шинээр үүсгэнэ.	Уурхайн нуруулт, гулсалт үүсэхээс сэргийлнэ.	Дотоод үйл ажиллагаагаар	Газрын хэвлийн тухай хууль	Уурхай үйл ажиллагаа эхлэлийн түвшинд явж байгаатай холбогдуулан БОНБНУ, болон ТЭЗҮ-д тусгагдсанаар уурхайн ажлын хажуугийн өнцгийг 55 ⁰ бариулан үүсгэж байна. Урт хугацаанд уурхайн гүнзгийрэлт ихсэж хажууг нуруулт гулсалт үүсгэхгүй тогтвортой байлгах үүднээс үндсэн паратемруудыг ашигласан.
5. Ургамлан нөмрөг					
5.1	Шимт хөрсний овоолго үүсгэх ажлын үед ургамал устгах дарагдах талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөнө.	Нөхөн сэргээлтэнд ашиглах хөрсний шимт хэсгийн овоолгыг стандартын дагуу тусгайлан овоолж салхинд хийсхээс хамгаалах	Дотоод үйл ажиллагаагаар	MNS5916:2008 газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт хадгалалт MNS5918:2008 эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага	Стандартын дагуу 3м өндөртэй овоолго үүсгэн салхинд хийсхээс хамгаалан дагтаршуулсан
5.2		Уурхайн нөлөөллийн бүсэд хээрийн судалгаа хийж, ургамлын бичиглэл хийх	2'000'000	БОНБНУ-д тусгагдсан	Уурхайн нөлөөллийн бүсэд байгаа ургамалуудыг төрөл зүйлээр нь бүртгэлжүүлэн ажиллаж байна.
6. Амьтны аймаг					

6.1	Амьтны аймагт хохирол учруулах тоо толгой хорогдох, идэш тэжээлийн хомсдол үүсэх	Мал амьтан өнгөрч гардаг хэсгүүдэд тэмдэг тэмдэглэгээ байрлуулах, авто машины хурдыг тогтоосон хязгаарт байлгах	150'000	Амьтаны тухай хууль: 6.1.3 ан амьтаны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, тархац нутгийг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй байлгах 6.1.7. үйлдвэрлэл аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устгахаас урьдчилан хамгаалах	Зам талбайгаар мал болон зэрлэг амьтад явах хэсгүүдэд зориулалтын анхааруулах тэмдэг тэмдэглэгээг зохих журмын дагуу байрлуулсан.
Нийт					59'827'674

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлтийг тайлан.

- Хүнд даацын техник хэрэгсэл, тэсэлгээний өрөм, хөнгөн тэрэг, хөрс тээврийн машинуудын хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор 20 тонны багтаамжтай 1ширхэг усны машин өдрийн ээлжинд мастерын нарядын дагуу тогтмол усалгаа хийж ажиллаж байна. /Зураг 1-т шүүрлийн ус цуглуулж буй байдал, Зураг 2-т усны машин болон зам усалгааны ажиллагаа үзүүлээ/
- Орчны тоосжилтыг бууруулахад шаардагдах усыг “Монголын алт” (МАК) ХХК-ны уурхайн шүүрлийн усны нуур болон өөрийн уурхайнд байгуулсан зумфээс соруулж ашигласан байгаа бөгөөд 2022 оны 09-р сараас 06-аас 2022 оны 10-р сар дуусах хугацаанд 3300м³ усыг тоосжилт дарахад ашиглаад байна. Тоосжилт дархад ашиглаж байгаа усны бүртгэлийг бүтээлийн хуудсаны бүртгэлээр баталгаажуулж хянаж байна.



Зураг-2 Шүүрлийн ус хуримтлагдсан байдал

Зураг-3 Замын усалгааны хийж буй байдал




Шимт хөрсийг гадаргуун шинж чанараас хамаарч 20-30см-ийн зузаантай хуулалт хийж бөөгнүүлж ачиж, тээвэрлэн шимт хөрсний овоолго үүсгэж стандартын дагуу хадгалж байна. Нийт 52842м³ шимт хөрс овоолсон байна.



Зураг-4 Шимт
хөрсний овоолго үүсгэж
буй байдал

- Уурхайн орчмын газрын гадаргуун өөрчлөлтийг бага байлгах үүндээс хөрсийг гэмтээхгүй, олон салаа зам гаргахаас сэргийлж зориулалтын технологийн замуудыг стандартын дагуу дунджаар 30см-ийн зузаантай хучилт хийсэн. Нийт 10.570 км зам тавьсан.



Зураг-5 Уурхайн хучилт хийгдсэн
замын план зураг

- Технологийн замын хурдны тэмдэг тэмдэглээг стандартын дагуу 10, 30, 40, 50 гэсэн хурдны хязгаарт тохируулан байршуулах, цацруулагч бүхий гадас тусгаарлагчыг шаардлагатай зам талбайд байршуулж ажилласан.



Зураг-6 Тэмдэг
тэмдэглэгээ
байриуулсан байдал



Зураг-7
Тэмдэг тэмдэглэгээ
байриуулсан байдал

- Орчны тоосжилтын хэмжилтийг уурхайн үйл ажиллагаа эхлэхийн өмнө байгаль орчны төв лабораторитой хамтарч 6, 7-р саруудад хяналтын 15 цэгээс дээж авч шинжилүүлж газар зохион байгуулалт геодези зураг зүйн газраар баталгаажуулсан.

ГАЗРЫН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА "ГЕОБОТАНИК" ХХК

ЗАХИАЛАГЧ: "ЕАИ" ХХК

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГУРВАНТЭС СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ
"ЕАИ" ХХК-ИЙН АШИГЛАЛТЫН ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ,
ЧАНАРЫН ЗАХИАЛГАТ ХЯНАН БАТАЛГАА

ГҮЙЦЭТГЭСЭН: ГАЗРЫН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА "ГЕОБОТАНИК" ХХК

ЗАХИРАЛ
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАГЧ-ИНЖЕНЕР Ц.ХАНБУРГЭД
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАГЧ-ИНЖЕНЕР Б.МЯГМАРЖАРГАЛ
ГАЗРЫН КАДАСТРЫН ИНЖЕНЕР Э.МЯГМАРҮСРЭН
ХӨРС СУДЛААЧ Н.ДАМБАДАРЖАА
УРГАМАЛ СУДЛААЧ Т.НАМУУН

Улаанбаатар хот
2022 он

ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Хянан баталгааны төрөл: Захиалгат
Огноо: 2022-08-12

1. Газар ашиглагч: "ЕАИ" ХХК
2. Аймаг (нийслэл): Өмнөговь
3. Байршил, хаяг: Шивээ хүрэн боомтын хатуу хучилттай авто замын баруун талд
4. Нэгж талбарын дугаар: MV-020781-05
5. Хөрсний нэр: Цөлийн бор саарал хөрс, 23055266701801
6. Ургамалжилт: Холимог сөөгт, У-VII-2-3
7. Нийт талбайн хэмжээ/м²: 1657.47 га
8. Газар эзэмших зориулалт: Уурхай
9. Одоогийн газар ашиглалтын хэлбэр: Уурхай
10. Газар ашиглах, эзэмших шийдвэр: Ашигт малтмал, газрын тосны газрын
Кадастрын хэлтсийн даргын 2022 оны 06 дугаар сарын 02-ны 266 тоот шийдвэр
11. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар: MV-020781
12. Эзэмшил газрын төлөв байдал, чанарын тодорхойлолт:

Газар ашиглалтын төрөл	Талбай, га	Үүнээс эвдэрсэн болон бохирдсон, талбайн хэмжээ, га/м ²		
		Физикийн	Химийн	Биологийн
Нийт эзэмшил газар	1657.47	+	-	-
Нэгж талбарын талбай	1657.47	+	-	-
Газар дээрээ ашиглаж байгаа талбай	1657.47	+	-	-
Зөвшөөрөлтэй ашиглаж байгаа талбай	1657.47	+	-	-
Үүнээс Нөлөөлөлд сул өртсөн талбай	1657.47	+	-	-

13. Газрын гадарга, төлөв байдал:
Тус нэгж талбар нь 1657.47 га талбайтай. Ашиглалтын талбайн баруун урд хэсэгт байрлалтай хойноос урагшаа сунаж тогтсон олон өнцөгт хэлбэртэй. Жижиг цав толгод хадархаг намхан уулс энгэр жалга дамнан байрласан. Уулсын салаа ам хэсгээр элсэрхэг хөрстэй. Хайрга чулуу хадархаг гадаргатай. Бэсрэг толгодын хормойгоос байнгын урсгалгүй хуурай сайр голдирол ихтэй. Хуурай олон салаа судга жалга дагуу харгана бударгана, бут сөөг тархсан. Одоогоор газар дээр үйл ажиллагаа явагдаагүй байна.

14. Хөрсний доройтол, бохирдолт, түүний төрөл, зэрэглэл:
Тус талбайн орчимд цөлийн бор саарал хөрс тархана. Хөрсний бохирдолгүй

Хөрсний химийн шинж чанар

Дээж авсан цэгийн дугаар	Ph	ЦДЧ, ds/m	Давс, %	Ялзмаг, %	CaCO ₃ , %	Солилцох суурь, мг-экв/100гр			Шим тэжээлийн элементүүд, мг/100 гр		
						Ca+Mg	Ca	Mg	NO ₃	P ₂ O ₅	K ₂ O
Дээж-11	8.29	0.989	0.396	1.13	1.12	27	18	11	1.75	4.3	14
Дээж-12	8.8	0.097	0.039	0.46	0	16	11	5	0.23	3.9	15
Дээж-13	8.4	0.976	0.39	0.94	0.96	13	9	4	0.75	2.5	17
Дундаж	8.5	0.89	0.28	0.84	0.69	18.6	12.0	6.6	0.9	3.5	15.3

Зураг-8 Газрын төлөв байдал чанрын хянан баталгаа хийлгэсэн байдал

- Уурхайн техникийн нөхөн сэргээлт хийгдсэний дараа талбайг эрүүлжүүлэх, анх байсан байгалийн онгон төрхийг хадгалах зорилгоор шимт хөрс хуулахын өмнө тухайн талбайн ургамалыг м² талбайд тархсан байгаа тархалт, овог зүйл, ургалт зэргээр нь бүртгэлжүүлсэн. Мөн уурхайн нөлөөлөлд өртөж буй хэсгийн судалгааны ажил үргэлжлэн явагдаж байна.

Хөрсний сувагийн үед ургамалын нөөргийн гарц, түймийн бүрэлдүүний бүтэц тэдгээгээр

Д/а	Огноо	Ургамалын эвчил	Байршил	Түймийн бүрэлдүүний тоо	1м ² талбайн түймийн тоо	Ургамалын бүрэлдүүн, %	Халдгай гярыг хэмжээ, %	Халдгай гярыг хэмжээ, %	Ургалт а/н га
1	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	40-50%	4.6	5	0.2
2	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	30-40%	4.0	4	0.1
3	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	30-40%	3.0	3	0.2
4	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	40-50%	3.5	3	0.1
5	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	40-50%	4.0	5	0.2
6	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	30-40%	4.5	2	0.3
7	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	30-40%	3.0	3	0.1
8	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	40-50%	3.0	4	0.2
9	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	50-60%	2.5	2	0.3
10	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	50-60%	3.0	4	0.2
11	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	50-60%	1.5	3	0.1
12	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	50-60%	4.0	4	0.2
13	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	50-60%	3.0	3	0.1
14	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	40-50%	3.5	2	0.2
15	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	50-60%	4.0	4	0.1
16	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	50-60%	3.0	3	0.2
17	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	50-60%	4.0	5	0.3
18	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	40-50%	4.0	4	0.2
19	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	40-50%	4.0	5	0.2
20	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	40-50%	4.0	5	0.1
21	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	40-50%	3.0	6	0.2
22	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	40-50%	3.0	4	0.2
23	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	40-50%	4.0	4	0.3
24	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	40-50%	3.0	5	0.3
25	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	40-50%	3.0	5	0.2
26	8/1/2022	Холимог сөөгт	Холимог сөөгт	6	3	40-50%	4.0	4	0.1



Зураг-9 Ургамалын судалгаа хийж буй байдал

- Засвар үйлчилгээний талбайд тос масло химийн бодис асгарч хөрсөнд шингэж хөрс бохирдохоос хамгаалж нийт талбайд хайрган хучилт хийсэн

*Зураг-10*

Засвар үйлчилгээний талбайд хайрган хучилт хийж буй байдал

- Шингэн хог хаягдлыг хөрсөнд нэвчүүлэхгүйн тул зөөврийн бохирын системд холбож Шугшаа уул ОНӨТҮГ-тай гэрээ хийн улиралд 1 удаа соруулах арга хэмжээ авч ажиллаж байна.



Зураг-11 Зөөврийн бохирын систем суурилуулж буй байдал

- Нийтийг хамарсан ажилчдын их цэвэрлэгээг хотхоны 500м радиусын дотор зохион байгуулсан.



Зураг-12
Их цэвэрлэгээ
хийж буй байдал

- Уурхайн кемпийн хойд хэсэгт 2.5км-т байрлах булаг шандны эх уст цэгийн цэвэрлэв.



Зураг-13
Булгын эхийг
цэвэрлэсэн байдал

- Техникуудад ашиглагдсан бүх төрлийн тос тосолын хаягдлыг баримтжуулан бүртгэл хөтлөн тос хадгалах 200л пошигнуудад хуримтлуулж “Монпити” ХХК-тай гэрээ хийж нийлүүлэлт хийхээр тос маслыг 200л пошигонд стандартын дагуу цуглуулж байна

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛЫН БҮРТГЭЛ						
№/д	Огноо	Аюултай хог хаягдалын нэр	Хог хаягдалын тоо ширээг, хэмжээ	Хаана хадгалсан байгаа /тодорхой бичих/	Хааны нийлгүүр/усласны, туушвсан	Хариуцаж устгаж, шилжүүлсэн ажиглан /албан тушаалтан, нэр/
1	9/10	Тосолыг баримтжуулах	3 ширээ	Хөдөөн тосолыг баримтжуулах	Анх ахуйн тосолыг баримтжуулах	Бүтэц хийсэн албан тушаалтан
2	9/10	Хөдөөн тосолыг баримтжуулах	40 л	Хөдөөн тосолыг баримтжуулах	Анх ахуйн тосолыг баримтжуулах	Бүтэц хийсэн албан тушаалтан
3	9/14	Орлог	3 ширээ	Хөдөөн тосолыг баримтжуулах	Анх ахуйн тосолыг баримтжуулах	Бүтэц хийсэн албан тушаалтан
4	9/16	Тосолыг баримтжуулах	40 л	Хөдөөн тосолыг баримтжуулах	Анх ахуйн тосолыг баримтжуулах	Бүтэц хийсэн албан тушаалтан
5	9/16	Тосолыг баримтжуулах	3 ширээ	Хөдөөн тосолыг баримтжуулах	Анх ахуйн тосолыг баримтжуулах	Бүтэц хийсэн албан тушаалтан
6	9/16	Тосолыг баримтжуулах	10 ширээ	Хөдөөн тосолыг баримтжуулах	Анх ахуйн тосолыг баримтжуулах	Бүтэц хийсэн албан тушаалтан
7	9/16	Хөдөөн тосолыг баримтжуулах	60 л	Хөдөөн тосолыг баримтжуулах	Анх ахуйн тосолыг баримтжуулах	Бүтэц хийсэн албан тушаалтан
8	9/16	Тосолыг баримтжуулах	3 ширээ	Хөдөөн тосолыг баримтжуулах	Анх ахуйн тосолыг баримтжуулах	Бүтэц хийсэн албан тушаалтан
9	10/5	Орлог	3 ширээ	Хөдөөн тосолыг баримтжуулах	Анх ахуйн тосолыг баримтжуулах	Бүтэц хийсэн албан тушаалтан

